



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/301

Мандалговь

"Дундговь түншлэл-2017" үзэсгэлэн, худалдаа  
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.3, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймаг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэн, малчин өрх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, экспортийг дэмжих инноваци болон өртөг шингэсэн шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулж урамшуулах, худалдан борлуулах орчин бүрдүүлэх зорилгоор "Дундговь түншлэл-2017" үзэсгэлэн худалдааг 2017 оны 9 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулсугай.

Хоёр. "Дундговь түншлэл-2017" үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэн, малчин өрх, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шалгаруулах номинаци, шалгуур үзүүлэлтийг гаргаж, нийт сумдын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг /Ж.Мөнхчулуун/-т үүрэг болгосугай.

Гурав. "Дундговь түншлэл-2017" үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Дөрөв. Үзэсгэлэн худалдаанд шаардлагатай 1.950.000 /Нэг сая есөн зуун тавин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг нягтлан бодогч /Ц.Даваа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

0200855